



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЛБАН ТУШААЛТНУУД АЛБАН ҮҮРГЭЭ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭС АВТО
ЗАМЫН АРЧЛАЛТ ХАНГАЛТГҮЙ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНД ТӨСВИЙН
ХӨРӨНГИЙГ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛЖЭЭ.

АУДИТЫН СЭДЭВ: “АВТО ЗАМЫН АРЧЛАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН”

АУДИТЫН КОД: ГАА-2024/33-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу

Цахим хуудас: www.tailan.audit.mn

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа

Утас: 70483413 цахим хуудас: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 цахим хуудас: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэнханд

Утас: : 99086371 цахим хуудас: tserenkhandd@audit.gov.mn

Аудитор Ц.Сайханжаргал

Утас: : 88665099 цахим хуудас: Saikhanjargalts@audit.gov.mn

Аудитор О.Энхтөр

Утас: : 95343496 цахим хуудас: enkhturo@audit.gov.mn

Алтай хот 2024 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	3
ДҮРСЛЭЛИЙН ТАЙЛБАР	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3
АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	4
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	5
БҮЛЭГ 1. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХГҮЙ БАЙНА.....	6
Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан авто замын арчлалт, засвар үйлчилгээний төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна. Сумдын Засаг дарга болон төрийн захиргааны байгууллагууд авто замын арчлалт, засвартай холбоотой чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна	
БҮЛЭГ 2. АЛТАЙ ХОТ ДОТОРХ ХАТУУ ХУЧИЛТАЙ АВТО ЗАМЫН АРЧЛАЛТ ХАНГАЛТГҮЙ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНД ТӨСВИЙН ХӨРӨНГИЙГ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛЖЭЭ.	9
.....	9
Шаардлагатай авто зам засварын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбийг харгалзан үзээгүй байна. Авто замын арчлалт хангалтгүй, засвар үйлчилгээнд төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулжээ.	
БҮЛЭГ 3. АВТО ЗАМЫН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГ ХӨТЛӨН ЯВУУЛАХ ЖУРМЫГ БАТЛААГҮЙ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮНД ТАВИХ ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА	
Аймгийн Засаг дарга холбогдох журам батлаагүйгээс авто замын бүртгэл мэдээллийн сан, холбогдох баримт бичгийг хөтлөөгүй байна. Авто замын арчлалт, засвар үйлчилгээний чанар байдалд тавих хяналт шалгалт үр нөлөөгүй байна.	
ДҮГНЭЛТ:	17
АУДИТЫН ШИЙДВЭР:	Error! Bookmark not defined.
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР.....	19
САНАЛД ӨГСӨН ХАРИУ ТАЙЛБАР:	19

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШТА	Шууд тайлагнах аудит
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт-1	Бодлогын баримт бичигт тусгасан төсөл арга хэмжээний хэрэгжилт	6
-----------	--	---

ДҮРСЛЭЛИЙН ТАЙЛБАР

Дүрслэл-1	Авто замын сангийн хөрөнгийн зарцуулалт 2020-2024 он	10
Дүрслэл-2	Иргэд олон нийтээс авсан санал асуулгын нэгтгэл -1	12
Дүрслэл-3	Иргэд олон нийтээс авсан санал асуулгын нэгтгэл -2	13
Дүрслэл-4	Иргэд олон нийтээс авсан санал асуулгын нэгтгэл -3	13

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг-1	Солонго хорооллын хөндлөн авто зам	8
Зураг-2	Солонгол хорооллын босоо авто зам	8
Зураг-3	Захын авто зам	8
Зураг-4	Баянхайрханы хөндлөн зам	8
Зураг-5	Хүүхдийн байгууллагын урдах зам	11
Зураг-6	Ахуйн үйлчилгээний урд талын зам	11
Зураг-7	Паркийн доод талын авто зам	11
Зураг-8	Солонго хорооллын замаас Баянхайрхан багийн дээд замын зүүн эргэлт	14
Зураг-9	Солонго хорооллын замын үргэлжлэл	14
Зураг-10	Нарлаг дэлгүүр болон хөгжил хорооллын уулзвар	14
Зураг-11	ХЭЦС-ийн урд тал, 48 дугаар байрны ард талын зам	14
Зураг-12	Хөгжил хорооллын хуулсан дунд зам	15
Зураг-13	ОБГ-ын урд талын хуулсан зам	15

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх, зорилго, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, багийн бүрэлдэхүүн

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3, 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162, “Аудитын сэдэв батлах” 2023 оны А/100 дугаар тушаалыг тус тус үндэслэн хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

Орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- *Авто замын арчлалт, засвар үйлчилгээтэй холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан эсэх;*
- *Авто замын арчлалт, засвар үйлчилгээг тогтмол үр дүнтэй зохион байгуулсан эсэх;*
- *Авто замын бүртгэл, мэдээллийн санг журмын дагуу хөтөлж, засвар үйлчилгээний үр дүнд тавих хяналт үр нөлөөтэй эсэх;*

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Авто замын тухай хуулийн хүрээнд орон нутгийн авто замын арчлалт, засвар үйлчилгээг хариуцдаг, хяналт хэрэгжүүлдэг хуулийн этгээдийн 2020-2024 оны баримт мэдээлэлд тулгуурлан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ажлын даалгавар, зураг төсөв, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитын хийж гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй

Аудитын стандарт АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-5:2020, “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, судалгаа авах, ярилцлага хийх арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

- Авто замын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын зохион байгуулалтын техникийн дүрэм (Зам тээврийн сайдын 2016 оны 37 дугаар тушаалын хавсралт)
- Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам (Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт)
- Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын зохион байгуулалтын журам УББ 13-202-00 (2000 он)
- Авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын жишиг норм ЗЗБНБД 83-20-2023 (2023 он)
- Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын арга технологи БНБД 1303-00 (2000 он)
- Холбогдох бусад хууль тогтоомж эрх зүйн актууд

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Цэрэнханд, аудитор Ц.Сайханжаргал, О.Энхтөр нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Говь-Алтай аймгийн хэмжээнд орон нутгийн шинж чанартай 104 авто зам, замын байгууламж, 5 гүүрийн байгууламж байна. Сүүлийн 5 жилд хийсэн авто зам засварын ажлуудыг дурдвал:

- Авто замын сангаас 2020 онд 151.1 сая төгрөг, 2021 онд 180.2 сая төгрөг, 2022 онд 416.0 сая төгрөгийн авто замын засварын ажлыг хийж, 2023-2024 онд засварын ажил хийгдээгүй.
- “АЗЗА” ТӨХК нь орон нутгийн чанартай 3 авто замд 2019-2023 онд 190.9 сая төгрөгийн засварын ажил хийсэн.
- Есөнбулаг сумын ОНХС-гаас 2019-2023 онд 60.0 сая төгрөгийн авто замын нөхөөсний ажил хийсэн.
- Сумдын ОНХС-гаас 2019-2023 онд 360.5 сая төгрөгийн авто замын засварын ажил хийсэн байна.

БҮЛЭГ 1. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНУУД АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХГҮЙ БАЙНА.

Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан авто замын арчлалт, засвар үйлчилгээний төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

- 1.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10 дугаар тогтоолоор “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл”, мөн оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталжээ.
- 1.2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 26 дугаар тогтоолоор “Аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”, 2022 оны 58 дугаар тогтоолоор “Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-г тус тус баталсан боловч 2021 оны төлөвлөгөөг батлаагүй байна.
- 1.3. Бодлогын баримт бичигт авто замтай холбоотой тусгасан төсөл, арга хэмжээний хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:¹

Хүснэгт -1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилт /хувиар/

Бодлогын баримт бичгийн нэр	2021 он		2022 он		2023 он	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл	4	7.5	4	7.5	4	7.5
Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	3	50.0	4	87.5	5	58.0
Аймгийн хөгжлийн төлөвлөгөө	-	-	3	50.6	6	82.5
Нийт дүн	7	28.5	11	48.5	15	49.3

- 1.4. Дунд хугацааны болон жилийн төлөвлөгөөнд тусгасан авто замын засвар, арчлалтын талаарх арга хэмжээний хэрэгжилт дунджаар 49.3 хувьтай байна.
- 1.5. Түүнчлэн аймгийн богино хугацааны бодлогын баримт бичигт авто замын арчлалт, засвартай холбоотой төсөл, арга хэмжээг тусгаагүй, зөвхөн шинээр авто зам барих төсөл, арга хэмжээг тусгажээ.
- 1.6. Бодлогын баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахдаа хамааралгүй асуудлыг тусгасан, хэрэгжилтийн хувийг бодитой тооцоогүй байна.
- 1.7. Энэ нь бодлогын баримт бичигт тусгасан авто замын арчлалт, засвар үйлчилгээний хэрэгжилтийг хангахгүй, хяналт тавьж ажиллахгүй байгаатай холбоотой байна.

¹ Бодлогын баримт бичгийн 2024 оны хэрэгжилт тайлагнах хугацаа болоогүй тул аудитад хамруулаагүй болно.

Сумдын Засаг дарга болон төрийн захиргааны байгууллагууд авто замын арчлалт, засвартай холбоотой чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

- 1.8. Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлд² аймаг, сумын Засаг даргын хэрэгжүүлэх бүрэн эрхийг 8 заалтаар тусгасан байна.
- 1.9. Аймгийн Засаг даргын хуульд заасан чиг үүргийн хэрэгжилт 2021-2023 онд дунджаар 55.0 хувьтай буюу хангалтгүй байна.
- 1.10. Сумын Засаг дарга нар 1-2 чиг үүргийн хүрээнд авто замын арчлалт, засварын талаар тодорхой арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн боловч түүний хэрэгжилтийг ханган ажилласан талаарх тайлан, судалгааг гаргадаггүй, авто замын талаарх хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байна. Тухайлбал:
 - Баян-Уул, Бугат, Есөнбулаг, Тонхил сумууд тайлан судалгаагүй.
 - Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт байгаа 12,985 метр 14 хатуу хучилттай авто замыг дансанд бүртгээгүй бөгөөд үүнээс 550 метр 2 хатуу хучилттай авто зам, 210 метр явган хүний бетонон замыг хуулсан.
- 1.11. Харин бусад 14 сумын Засаг дарга хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй, авто замын арчлалт, засварын ажлыг зохион байгуулаагүй байна.
- 1.12. Авто замын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т³ зааснаар орон нутгийн чанартай авто замын эзэмшигч нь аймгийн Засаг дарга байхаар, 23 дугаар зүйлд⁴ эзэмшигч нь зам хариуцах тусгай зөвшөөрөл бүхий этгээдэд хариуцах замын чиглэл, уртыг тогтоон хариуцуулахаар заажээ.

²12.1.1.үндэсний авто замын сүлжээг хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулан нийслэл, орон нутгийн чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх бодлого, ерөнхий төлөвлөгөөг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах;

12.1.2.авто замын тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх;

12.1.3.нийслэл, орон нутгийн чанартай авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах ажлыг зохион байгуулах;

12.1.4.нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдах авто замын барилга, засвар, арчлалтын ажлыг зохион байгуулах;

12.1.5.олон улс, улсын болон орон нутгийн чанартай, тусгай зориулалтын авто замын бүрэн бүтэн байдлыг хангах, хамгаалах талаар харьяа нутаг дэвсгэрийн байгууллага, иргэнд үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хангуулах;

12.1.7.байгалийн гамшиг, гэнэтийн осол, аюулын улмаас үүссэн авто замын эвдрэл, гэмтлийг шуурхай засварлах шаардлага гарсан үед харьяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс тээвэр, холбооны хэрэгсэл, машин механизм, эд хөрөнгийг нөхөн олговортойгоор дайчлан гаргуулах, хүн хүчний тусалцаа авах ажлыг зохион байгуулах;

12.1.8.харьяа нутаг дэвсгэртээ авто замын хөдөлгөөнийг зохих хууль, журмын дагуу зохион байгуулах, зохицуулах;

12.1.9.аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулж, батлуулахдаа авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч тусгах.

³17.3.Нийслэл, орон нутгийн чанартай авто зам, түүний зурвас газрыг эзэмшигч нь аймаг, нийслэлийн Засаг дарга, түүнээс эрх олгосон этгээд байна.

⁴23.1.Авто замын ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, арчлалт, урсгал засварын ажлыг тогтмол гүйцэтгэх чиг үүрэг бүхий зам хариуцагч байгууллага байна. Зам хариуцагч байгууллага нь замын арчлалт, засварын ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрөл бүхий төрийн болон хувийн өмчит хуулийн этгээд байна.

23.2.Зам хариуцагч байгууллагын хариуцах замын чиглэл, уртыг тухайн авто замыг эзэмшигч тогтооно.

- 1.13. Аймгийн Засаг дарга хариуцах замын чиглэл, уртыг тогтоох талаар хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байгаа нь орон нутгийн хэмжээнд зам хариуцах тусгай зөвшөөрөл бүхий төрийн болон хувийн өмчит этгээд байхгүйгээс шалтгаалсан байна.
- 1.14. Харин Есөнбулаг сумын авто замын арчлалтыг Алтай хотын тохижилт үйлчилгээний газар сумын Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэж байна.
- 1.15. Тус байгууллага авто замын арчлалт, засварын ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрөлгүй, мэргэжлийн ажиллах хүчингүй байна.
- 1.16. Есөнбулаг сум дахь авто замын тэмдэг тэмдэглэгээг засварлах, авто замын хөвөөг цэвэрлэх, өвлийн улиралд халтиргаа гулгааг арилгах, давс цацах ажлыг гүйцэтгэдэг ч засварыг хариуцдаггүй байна.
- 1.17. Авто замын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2⁵-д авто зам ашиглагч этгээдийн үүрэг хариуцлагыг тусгасан байна.
- 1.18. Авто зам ашиглагч этгээдийн үйл ажиллагаатай холбоотой гомдол, мэдээлэл төрийн байгууллагуудад 2020-2024 онд бүртгэгдээгүй байна.
- 1.19. Алтай хотын төвд байрлалтай хатуу хучилттай дараах 4 авто зам нь ашиглагч этгээдийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан ашиглалтын шаардлага хангахгүй, сүүлийн 2-3 жил эвдэрсэн байдалтай байна.

[Зураг-1 Солонго хорооллын хөндлөн зам](#) [Зураг-2 Солонго хорооллын босоо зам](#) [Зураг-3 Захын зам](#) [Зураг-4 Баянхайрхан хөндлөн зам](#)



- 1.20. Есөнбулаг сумын Засаг дарга дээрх авто замуудын эвдэрсэн талаарх дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гаргуулаагүй, буруутай этгээдийг тодорхойлон зөрчлийг арилгуулах талаар арга хэмжээ аваагүй байна.

Илрүүлэлт:

- Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан авто замын арчлалт, засвар үйлчилгээний төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй.
- Сумдын Засаг дарга нар, төрийн захиргааны байгууллагууд авто замын талаар хэрэгжүүлэх бодлого арга хэмжээ, түүний хэрэгжилтийг ханган ажилласан талаарх тайлан, судалгааг гаргадаггүй.

⁵ 29.2.Авто зам ашиглагч нь дараахь эрх, үүрэгтэй:

- Авто замын ашиглагч 2 хуулийн этгээд 4 хэсэгт байрлах авто замаар хүнд даацын авто машинаар зорчиж, эвдэрсэн, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулаагүй, авто замыг хэвийн байдалд оруулж засварлаагүй.


БҮЛЭГ 2. АЛТАЙ ХОТ ДОТОРХ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН АРЧЛАЛТ ХАНГАЛТГҮЙ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНД ТӨСВИЙН ХӨРӨНГИЙГ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛЖЭЭ.

Авто замын сангаас шаардлагатай авто зам засварт хөрөнгө төлөвлөөгүй, хөрөнгө оруулалтын эрэмбийг харгалзан үзээгүй байна.

- 2.1. Аймгийн хэмжээнд 2024 оны байдлаар 3,108.4 сая төгрөгийн 14 асбалт, бетонон авто зам, 498.3 сая төгрөгийн 10 цементэн цутгамал зам, 249.1 сая төгрөгийн 5 сайжруулсан хайрган зам, 210.0 сая төгрөгийн 5 гүүрний байгууламж, 228.2 сая төгрөгийн 11 бусад хөрөнгө нийт 109 авто зам, замын байгууламж дансанд бүртгэлтэй байна.
- 2.2. Дансанд бүртгэлтэй авто замын 87.7 хувийг Алтай хотын асбалт, цементэн хучилттай авто зам, 12.3 хувийг бусад сумдын цементэн, хайрган хучилттай авто зам эзэлж байна.
- 2.3. Хатуу хучилттай 24, хайрган хучилттай 5 авто замаас ашиглалтын хугацаа дууссан 3, ашиглалтын хугацаа дуусаагүй 26 авто зам байна. Харин бүртгэлгүй 14 авто зам байна.
- 2.4. Сумын ОНХС, авто замын сангийн 646.6 сая төгрөгөөр данс бүртгэлд тусгаагүй 14.9 км урттай 14 авто замыг 2020-2024 онд засварлахаар төлөвлөсөн байна. Үүний 34.9 хувийг Алтай хот доторх хатуу хучилттай авто зам засварт, 65.1 хувийг бусад сумдын зам, давааны засварт зарцуулахаар төлөвлөжээ.
- 2.5. Алтай хотын авто замын засварт авто замын сангаас 2021 онд 171.4 сая төгрөг, сумын ОНХС-гаас 2024 онд 54.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн боловч бусад онуудад хөрөнгө төлөвлөөгүй байна.

Авто замын сан:

Дүрслэл-1 Авто замын сангийн хөрөнгийн зарцуулалт 2020-2024 он, сая төгрөг



2.6. Авто замын сангаас 2020-2024 онд 1,473.5 сая төгрөгийг төлөвлөсний 871.1 сая төгрөг буюу 60.0 хувийг шинээр авто зам барихад, 280.9 сая төгрөг буюу 19.0 хувийг авто замын засвар үйлчилгээнд, 321.4 сая төгрөг буюу 22.0 хувийг замын тохижилт (явган зам, тэмдэг тэмдэглэгээ, гэрлэн дохио)-ын ажилд зарцуулсан байна.

- 2.7. Авто замын сангийн хөрөнгийн 60.0 хувийг шинээр авто зам барихаар төлөвлөсөн нь нэн тэргүүнд шаардлагатай засварын ажлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах

нөхцөлийг үүсгэсэн байна. Энэ нь Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3⁶, Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт "Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7⁷ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.8. Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн авто замын засварын 14 төсөл, арга хэмжээнээс 382.1 сая төгрөгийн өртөгтэй 8 төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, ажлын даалгавар, баталсан төсөвгүй байна. Үүнд:

- Жаргалан сумын "Алтай-Хүнхэр чиглэлийн авто замыг хэсэгчлэн засах.
- Алтай сумын даваа засвар
- Алтай сумын "Хавцгайтын ам засвар"
- Шарга сумын "Хамтын хүч багийн зам засвар арчлалт"
- Шарга сумын "Сондуулт багийн зам засвар"
- Цогт сумын "Бумбатын давааны засвар арчлалт"
- Эрдэнэ сумын "Замтын даваа засвар"
- Бугат сумын "Баянголын ам засах"

2.9. Авто замын засварын 14 төсөл, арга хэмжээний 4 зам засварын ажлыг нээлттэй тендер шалгаруулалтаар, 10 зам засварын ажлыг гэрээ шууд байгуулах аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Авто замын арчлалт хангалтгүй, засвар үйлчилгээнд төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулжээ.

2.10. Сумдад 2020-2024 онд авто замын засвар үйлчилгээг гүйцэтгүүлэхээр 646.6 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан байна. Үүнээс 226.2 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ нь Есөнбулаг сумд, 420.4 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ нь бусад сумдад хэрэгжсэн.

2.11. Есөнбулаг сумд 2021 онд 171.4 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ, 2023 онд 39.8 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ, 2024 онд 15.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна.

2.12. Эдгээр зам засварын ажлыг дүрэм, журам, технологийн дагуу гүйцэтгээгүй, ашиглалтын хугацаа дууссан, насжилт өндөртэй авто замуудад хийснээр хууларч унан, дахин засвар хийх шаардлагатай болсон байна.

2.13. Аймгийн хэмжээнд ашиглаж байгаа авто замын 52.0 хувь иргэдийн амьдрах тухтай орчныг бүрдүүлж чадахгүй байна.

⁶ Улсын авто замын сангийн хөрөнгөөр олон улс, улсын чанартай авто замын, нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ"

⁷ Авто замын сангийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.


Зураг-5 Хүүхдийн байгууллагын урдах зам



Зураг-6 Ахуйн үйлчилгээний урд талын зам



Зураг-7 Паркийн доод талын зам



- 2.14. Есөнбулаг суманд 2021 онд хэрэгжсэн “Алтай хотын төвийн хатуу хучилттай авто замын нүхний нөхөөс хийх засвар” төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлын 70.0 хувийг гүйцэтгэсэн байхад комисс ажиллан хүлээн авсан байна. Тус компани төсөвт өртгийг нэмэх хүсэлт ирүүлсэн байна.
- 2.15. Цогт сумын “Бумбатын давааны засвар”-ын ажлыг гүйцэтгүүлэхээр 30.0 сая төгрөгөөр гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгч ажлын 50.0 хувийг гүйцэтгэсэн байна. Тус компани зардал өндөр гарах тул үргэлжлүүлэн хийх боломжгүй гэж мэдэгдсэн байна.
- 2.16. Цогт сумын ЗДТГ дээрх дутуу ажлыг гүйцэтгүүлэхээр иргэнтэй 15.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. Тус иргэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн нийтийг хамарсан ажлын тайланг ирүүлсэн.
- 2.17. Тус ажлыг гэрээнд заасан ажлыг гүйцэтгэсэн эсэх нь баримтаар нотлогдохгүй, тус ажлыг хүлээн авсан актгүй, гэрээг дүгнээгүй байна.


Хүснэгт-2 Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний чанар, ашиглалтын байдал

Он	Төсөл арга хэмжээний тоо	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/	Гэрээнд заасан чанарын баталгаат хугацаа /тоогоор/				Ашиглалтын шаардлага хангаж байгаа эсэх (2024 оны байдлаар)		Хүлээн авсан ТАХ
			1 жил	2 жил	3 жил	Хугацаа заагаагүй	Тийм	Үгүй	
2020	1	151.0			1			1	1
2021	1	171.4	1					1	1
2022	6	120.0	1	1	2	2	5	1	6
2023	5	189.2	3	1		1	3	2	5
2024	1	15.0	1					1	1
дүн	14	646.6	6	2	3	3	8	6	14


- 2.18. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд чанарын баталгаат хугацааг 1-3 жилээр харилцан адилгүй тогтоосон, 3 гэрээнд чанарын баталгаат хугацааг тусгаагүй байна.
- 2.19. Авто зам засварын 14 төсөл, арга хэмжээнээс 2024 оны байдлаар ашиглалтын чанарын шаардлага хангаж байгаа 8, хангахгүй 6 төсөл, арга хэмжээ байна. Авто замыг зассаны дараа байгалийн гамшгийн улмаас эвдэрч, дахин засах шаардлага гарсан байна. Хэрэгжсэн 14 төсөл, арга хэмжээнээс дутуу хэрэгжсэн 2 төсөл, арга хэмжээ байна.

Дүрслэл-2 Иргэдээс авсан санал асуулгын нэгтгэл

Таны амьдарч буй нутаг дэвсгэрийн авто замын чанар байдал хэр вэ?
53 хариулт




Та хаана амьдардаг вэ?
53 хариулт




- 2.20. Санал асуулгад оролцсон иргэдийн 49.1 хувь Есөнбулаг, 7.5 хувь Цогт, 15.1 хувь Эрдэнэ, 11.3 хувь Алтай, 13.2 хувь Бугат, 3.8 хувийг Жаргалан сумууд тус тус эзэлж байна. Нийт санал асуулгад оролцсон иргэдийн 75.5 хувь нь авто замын чанар муу, маш муу гэж дүгнэжээ.
- 2.21. Авто замын тухай хуульд "зам хариуцагч" гэж захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр авто зам, замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдал болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор засвар, арчлалтын ажлыг тогтмол гүйцэтгэх эрх бүхий хуулийн этгээдийг тодорхойлсон байна.
- 2.22. Сумдын зам хариуцагч ЗДТГ, Алтай хот доторх орон нутгийн чанартай авто замын зам хариуцагч Есөнбулаг сумын ЗДТГ байна. Есөнбулаг сумын ЗДТГ "Алтай хотын тохижилт үйлчилгээний газар"-т замын арчлалтын ажлыг гэрээгээр хариуцуулсан байна.
- 2.23. Алтай хотын тохижилт үйлчилгээний газрын тохижилтын хэлтэс замын арчлалт, цэвэрлэгээ үйлчилгээг хариуцдаг 14 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.
- 2.24. Зам талбайн 1 үйлчлэгчид хэдэн метр зам талбай ногдож байгааг тогтоосон норм, норматив байхгүй бөгөөд тус газраас ажлын зураг авалт хийж, сард 1 хүнд ойролцоогоор 700-1790 метр зам талбай ногдохоор хуваарилсан байна.
- 2.25. Алтай хот доторх 24.8 километр авто замаас 15.3 километр авто замын арчлалтыг "Алтай хотын тохижилт үйлчилгээний газар" хариуцан хийж байгаа бол 9.6 километр авто зам хариуцах эзэнгүй байна.
- 2.26. Замын арчлалтыг ажлыг гэрээгээр гүйцэтгэж буй газар нь цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол, үр дүнтэй гүйцэтгэж байгааг нотлох ажлын тайлан, баримт ирүүлээгүй.

Дүрслэл-3 Иргэдээс авсан санал асуулгын нэгтгэл

Танай сум авто замын арчлалт, засвар үйлчилгээг тогтмол хийдэг үү?
53 хариулт




Таны амьдарч буй нутаг дэвсгэрийн авто замын арчлалт, засвар үйлчилгээний чанар байдал хэр байдаг вэ?
53 хариулт




- Түүнчлэн 41.5 хувь нь авто замын арчлалт, үйлчилгээг хийдэггүй гэсэн бол 9.4 хувь нь тийм гэж хариулсан байна. Арчлалт, үйлчилгээ хийдэггүй гэсэн шалтгаан тайлбарыг тодруулбал техник, төсөв байхгүй, чанаргүй хийдэг, шороогоор зам нөхдөг гэх тайлбарыг өгчээ.
- Харин хийгдэж буй арчлалт, засвар үйлчилгээний чанар байдлыг нийт судалгаанд оролцсон иргэдийн 62.2 хувь нь маш муу, муу гэж хариулжээ.

Дүрслэл-4 Иргэдээс авсан санал асуулгын нэгтгэл

Танай сум авто замын арчлалт, засвар үйлчилгээг тогтмол хийдэг үү?
53 хариулт



Таны амьдарч буй нутаг дэвсгэрийн авто замын арчлалт, засвар үйлчилгээний чанар байдал хэр байдаг вэ?
53 хариулт



- Авто замын эвдрэлийн шалтгааны 58.5 хувь чанаргүй хийгдсэнээс гэсэн бол 28.3 хувь арчлалт, засвар үйлчилгээг хийгээгүйгээс гэж хариулжээ. Санал асуулгад хамрагдсан иргэдийн 52.8 хувь авто замын чанар байдлаас шалтгаалан хохирол учирч байсан гэж хариулжээ.
- Авто замын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 4.1-д заасан зөвшөөрлийг олон улс, улсын чанартай замыг сэтлэх, орц, гарц гаргах тохиолдолд авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замыг сэтлэх, орц, гарц гаргах тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно" гэж заасан.
- Есөнбулаг сумын Засаг даргаас 2020-2024 онд Алтай хотын хатуу хучилттай авто замыг сэтлэх 29, орц, гарц гаргах 34 нийт 63 зөвшөөрөл олгожээ.

- 2.6. Авто замыг сэтлэх 29 зөвшөөрөл олгосноос 17 ажилд “авто замыг сэтлэн буцаан хэвийн байдалд оруулах” гэрээг байгуулаагүй.
- 2.7. “Авто замыг сэтлэн буцаан хэвийн байдалд оруулах гэрээ”-нд чанарын баталгаат хугацааг 1 жил байхаар тооцсон боловч баталгаат хугацаа өнгөрсний дараа эвдрэлд орсон 1 зам сэтэлгээ, асбалтон хучилт хийгээгүй, шороогоор дүүргэсэн 3 зам сэтэлгээ байна.

Зураг-8 Солонго хорооллын замаас Баянхайрхан багийн дээд замын зүүн эргэлт
Зураг-9 Солонго хорооллын замын үргэлжлэл
Зураг-10 Нарлаг дэлгүүр болон Хөгжил хорооллын уулзвар
Зураг-11 ХЭЦС урд тал 48-р байрны ард



Илрүүлэлт:


- Авто замын сангаас 2021 онд 171.4 сая төгрөг, ОНХС-гаас 2024 онд 54.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, бусад онуудад хөрөнгө төлөвлөөгүй.
- Авто замын сангийн хөрөнгийн 60.0 хувь буюу 871.1 сая төгрөгийг шинээр авто зам барихаар төлөвлөсөн нь нэн тэргүүнд шаардлагатай засварын ажлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах эрсдэлийг үүсгэсэн.
- Алтай хот доторх замын нөхөөсийг ашиглалтын хугацаа дууссан, насжилт өндөртэй 4 авто замд 174.7 сая төгрөгөөр хийсэн боловч хуйларч унан, дахин засвар хийх шаардлага гарсан.
- Хот доторх 24,849 метр 21 авто замыг Алтай хотын тохижилт үйлчилгээний газар хариуцдаг боловч хүний нөөцийн дутагдалтай байдлаас 9,545 метр 7 авто замыг хариуцах эзэнгүй арчлалт, үйлчилгээ огт хийгдэхгүй бөгөөд нийт замын 62.4 хувийг эзэлсэн.
- Авто зам сэтэлсэн ажлыг хүлээж аваагүйгээс 4 авто замыг хэвийн байдалд оруулаагүй, чанар байдал шаардлага хангахгүй.

БҮЛЭГ 3. АВТО ЗАМЫН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГ ХӨТЛӨН ЯВУУЛАХ ЖУРМЫГ БАТЛААГҮЙ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮНД ТАВИХ ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.


Аймгийн Засаг дарга холбогдох журам батлаагүйгээс авто замын бүртгэл мэдээллийн сан, холбогдох баримт бичгийг хөтлөөгүй байна.

- 3.1. Аймгийн хэмжээнд 2020-2024 онд хэрэгжсэн авто зам засварын 595.4 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээг хариуцагч байгууллагад хүлээлгэн өгсөн байна.
- 3.2. Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт байрлах 12.9 км 14 хатуу хучилттай авто замыг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй бөгөөд үүнээс 550 метр 2 хатуу хучилттай авто зам, 210 метр явган хүний бетонон замыг 2020 онд хуулсан байна.

Зураг-12 Хөгжил хорооллын хуулсан дунд зам



Зураг-13 Онцгой байдлын газрын үрд хуулсан зам



- 3.3. Алтай хот доторх 10 км авто замыг 2022-2024 онд шинээр барихаар Түм дэлгэрэх ХХК-тай гэрээ байгуулсан байна. Тус авто замын 4.1 км-т хатуу хучилт хийсэн, 3.9 км авто замын газар шорооны ажил хийсэн бөгөөд гэрээний хугацаа 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр дууссан байна. Гэвч ашиглалтад хүлээж аваагүй, гэрээг сунгах хүсэлтээ өгсөн байна. Эхэлж хийсэн зарим авто замууд эвдэрсэн, хийсэн нөхөөс дахин хууларсан байдалтай байна.
- 3.4. Авто замын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.3⁸-т зааснаар авто зам хариуцагч байгууллага нь авто замын бүртгэл мэдээллийн сан хөтөлж, замын паспорт, карт хөтлөхөөр заасан байна.
- 3.5. Бүх сумдын ЗДТГ, Алтай хотын тохижилт үйлчилгээний газар хатуу хучилттай авто замын паспорт, картыг хөтлөөгүй.
- 3.6. Аймгийн Засаг дарга Авто замын тухай хуулийн 27.4⁹-т орон нутгийн чанартай авто замын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журмыг баталж, мөрдүүлээгүй байна.

⁸ хариуцсан авто замын бүртгэл, мэдээллийн санг хөтөлж, нэгдсэн бүртгэлд оруулах

⁹ Олон улс, улсын болон тусгай зориулалтын авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, нийслэл, орон нутгийн чанартай 9 9

Авто замын арчлалт, засвар үйлчилгээний чанар байдалд тавих хяналт шалгалт үр нөлөөгүй байна.

- 3.7. Аймаг, сумдын Засаг дарга авто замын эргүүлийн үзлэг, хяналт шалгалтыг зохион байгуулаагүй байна.
- 3.8. Хэрэгжсэн 9 төсөл, арга хэмжээний явцын хяналтыг захиалагчаас хэрэгжүүлээгүй байна. Хяналт сул байгаагаас зам засварын төсөл, арга хэмжээний хэрэгжилт чанар байдал муутай, үр дүнгүй хөрөнгө оруулалт болсон байна.
- 3.9. Хяналт тавих эрх бүхий этгээдүүд албан үүргээ хэрэгжүүлээгүй нь Авто замын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1¹⁰ дахь заалтыг зөрчсөн байна.
- 3.10. Аймаг, сумдын Засаг дарга, Алтай хотын тохижилт үйлчилгээний газар авто замын арчлалт, засвартай холбоотой хяналтыг хэрэгжүүлэхгүй байна.
- 3.11. Авто замын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2¹¹ авто замын зөвлөлийн ажиллах журмыг батлахаар заасан. Гэвч журам батлаагүйгээс “Авто замын зөвлөл” байгуулаагүй байна.

Илрүүлэлт:

- Аймгийн хэмжээнд авто замын ашиглалтын паспорт болон картыг хөтлөөгүй.
- Аймгийн Засаг дарга нь орон нутгийн чанартай авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журмыг баталж, хэрэгжүүлээгүй.
- Аймаг, сумдын Засаг дарга, түүний эрх олгосон этгээд нь авто замын арчлалт, засвартай холбоотой хяналтыг хэрэгжүүлээгүй
- Авто замын зөвлөлийн ажиллах журмыг баталж, хэрэгжүүлээгүй.

9 авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга баталж, мөрдүүлнэ

¹⁰ Авто замын тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад учруулсан хохирлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтан гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ

¹¹ Авто замын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална

ДҮГНЭЛТ:

Аудитын нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан авто замын арчлалт, засвар үйлчилгээний төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, албан тушаалтан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.
2. Шаардлагатай авто зам засварын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбийг харгалзан үзээгүй, авто замын засвар үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө, гүйцэтгэлийн чанарт үе шатны хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
3. Аймгийн Засаг дарга холбогдох журам батлаагүйгээс авто замын бүртгэл мэдээллийн сан, холбогдох баримт бичгийг хөтлөөгүй байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

АЛБАН ТУШААЛТНУУД АЛБАН ҮҮРГЭЭ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭС АВТО ЗАМЫН АРЧЛАЛТ ХАНГАЛТГҮЙ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНД ТӨСВИЙН ХӨРӨНГИЙГ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛЖЭЭ.

Аудитын дүгнэлтэд үндэслэн аймгийн Засаг даргад 174.8 сая төгрөгийн 4 заалт, Есөнбулаг сумын Засаг даргад 3 заалт, Алтай, Бугат, Шарга, Эрдэнэ сумдын Засаг даргад тус бүр 1 заалт, Алтай хотын тохижилт үйлчилгээний газар 1 заалт, нийт 7 албан тушаалтанд 12 заалт зөвлөмжийг тус тус хүргүүлж, Үндэсний аудитын газарт 1 саналыг уламжилсан.

САНАЛ

Үндэсний аудитын газарт:

1. Авто замын тухай хуулийн дагуу “Авто замын зөвлөлийн ажиллах журам”-ыг баталж, хэрэгжүүлэхийг эрх бүхий этгээдэд уламжлах.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг даргад:

1. Аймгийн дунд болон богино хугацааны хөгжлийн төлөвлөгөөнд орон нутагт шаардлагатай байгаа авто замын төсөл, арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлж ажиллах.
2. Авто замын сан, Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр шаардлагатай авто замын засвар үйлчилгээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах.
3. Орон нутгийн чанартай авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журмыг баталж, хэрэгжүүлэх.
4. Авто замын арчлалт, засвартай холбоотой хяналтыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах.

Есөнбулаг сумын Засаг даргад:

1. Авто замын талаар хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээ, түүний хэрэгжилтийг ханган ажиллах.
2. Авто замын 4 хэсэгт байрлах эвдэрсэн авто зам, хатуу хучилттай сэтэлсэн 4 авто замуудыг хэвийн байдалд оруулж засварлах арга хэмжээг авч ажиллах.
3. Шинэ баригдсан авто замтай уялдуулж авто замын арчлалт, цэвэрлэгээ үйлчилгээнд зарцуулах санхүүгийн болон хүний нөөцийг оновчтой төлөвлөж, хэрэгжүүлэх.

Алтай, Бугат, Шарга, Эрдэнэ сумын Засаг даргад:

1. Авто замын талаар хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээ, түүний хэрэгжилтийг ханган ажиллах.

Алтай хотын тохижилт үйлчилгээний газарт:

1. Аймгийн хэмжээнд авто замын ашиглалтын паспорт болон картыг хөтөлж хэвших

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР
САНАЛД ӨГСӨН ХАРИУ ТАЙЛБАР:



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг, 82093
Утас/Факс: 7048-4042, Цахим шуудан: info@govi-altai.gov.mn

2024. 12. 24 № 8/1520


танай _____ -ны № _____ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Авто замын арчлалт, засвар үйлчилгээний үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд тусгах санал байхгүй болно.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЧИНЗОРИГ



8206381620

